



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1996 оны 10 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 263

Улаанбаатар
хот

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
бүтцийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 61 дүгээр зүйлийн 4, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1, 3 дугаар заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Нийслэлийн удирдлагыг Засаг даргаас гадна Засаг даргын орлогч 1 байхаар тогтоосугай.

2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг доорхи байдлаар тогтоосугай:

- а/Төрийн захиргааны удирдлагын хэлтэс;
- б/Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс;
- в/Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтэс;
- г/Нийгмийн бодлогын хэлтэс.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга нь Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга байна.

3. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй дор дурдсан нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагийг ажиллуулахаар тогтоосугай:

- а/Цагдаагийн газар;
- б/Татварын хэлтэс;
- в/Нийгмийн даатгалын алба;
- г/Гаалийн газар;
- д/Боловсролын газар;
- е/Эрүүл мэндийн газар;
- ж/Нийтлэг үйлчилгээний газар;
- з/Санхүүгийн хяналт шалгалтын алба;
- и/Байгаль орчны хяналтын газар;
- к/Мэргэжлийн хяналтын газар;
- л/Барилга, хот тохижилтын газар;
- м/Хүнс, хөдөө аж ахуйн газар;
- н/Өмчийн газар;

о/Залуучууд, спортын хэлтэс;
ө/Соёлын хэлтэс.

4.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг 65 /үйлчилгээний орлогоос цалинждаг болон нормативаар ажиллах орон тоо орохгүй/ байхаар тогтоосугай.


5.Энэ тогтоолын дагуу нийслэлийн дүүргийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарын талаар санал боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай зөвшилцсөний үндсэн дээр тогтоох арга хэмжээг энэ оны 11 дүгээр сард багтаан авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг даргад даалгасугай.

6.Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь тухайн шатны Хуралд үйлчилж байхаар тогтоосугай.

7.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 1993 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 65 дугаар тогтоолын 1, 2, 3, 4, 5 дугаар зүйл болон 6 дугаар зүйлийн “Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын орон тооны хязгаарыг 71,...” гэсэн хэсэг болон 7 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Хууль зүйн сайд



М.ЭНХСАЙХАН

Ж.АМАРСАНАА